

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны .... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.6 дахь хэсэг:**

"3.1.6."мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээ" гэж төрийн жинхэнэ албан хаагч албан тушаалын тодорхойлолтод заасан ерөнхий болон тусгай шаардлага, ур чадварын шаардлагыг хангаж байгаа эсэхийг тогтоох шалгалтыг."

**2/4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэг:**

"4.8.Төрийн захиргааны албан хаагчид олгох нөхөх төлбөр, тусламж, нийтлэг болон нэмэгдэл баталгааг энэ хуулиар, төрийн тусгай албан хаагчийн баталгааг энэ хуульд заасантай нэгэн адил байхаар холбогдох хуулиар тогтооно."

**3/16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг:**

"16.4.Үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчийн тоо 15 хувиас ихгүй байна."

**4/19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэг:**

"19.3.Яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагын Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дагуу нууцалбал зохих албан тушаалаас бусад төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу Засгийн газар тогтооно."

**5/23 дугаар зүйлийн 23.7 дахь хэсэг:**

"23.7.Засгийн газрын ажлын алба, яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албаны тэргүүн түшмэлийн албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн захиргааны албаны бусад албан тушаалын тодорхойлолтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална."

### **6/26 дугаар зүйлийн 26.5-26.7 дахь хэсэг:**

“26.5.Улаанбаатар хотоос бусад орон нутагт ажиллах төрийн албан хаагчийг тухайн орон нутагт 3-аас доошгүй жилийн хугацаагаар ажиллах нөхцөлтэйгээр энэ хуулийн 26.3-т заасан хугацаанаас өмнө шатлан дэвшүүлж болно.

26.6.Байгууллагын зорилго, зорилтын тэргүүлэх чиглэл, цаг үеийн зайлшгүй шаардлагыг харгалзан Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллага, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу байгуулагдсан олон улсын бусад байгууллагад 5-аас дээш жил ажилласан, өндөр мэдлэг, ур чадвар, туршлага бүхий, мэргэшсэн хүнийг төрийн захиргааны албан тушаалд 5 хүртэл жилийн хугацаагаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын зөвшөөрснөөр томилж, хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллуулж болно.

26.7.Энэ хуулийн 26.6-д заасан үндэслэлээр томилогдох хүний хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.5-д заасны дагуу Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хянуулна.”

### **7/31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалт:**

“31.1.4.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон бол;”

### **8/47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалт:**

"47.1.4.энэ хуулийн 52.4-т заасан мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээгээр “хангалтгүй” дүгнэгдсэн;”

### **9/52 дугаар зүйлийн 52.4-52.7 дахь хэсэг:**

"52.4.Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээ хийх ажлыг яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагад төрийн албаны төв байгууллага 2 жил тутамд нэг удаа зохион байгуулна.

52.5.Төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална.

52.6.Энэ хуулийн 52.5-т заасан журмыг хүний нөөцийн чиглэлээр мэргэшсэн төрийн бус байгууллага, мэргэжлийн холбооны оролцоог хангаж, олон улсын жишигт нийцүүлэн боловсруулна.

52.7.Төрийн байгууллага төрийн жинхэнэ албан хаагчийн мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээг хөндлөнгийн, хараат бус, мэргэшсэн байгууллагаар хийлгэж болно. "

### **11/57 дугаар зүйлийн 57.17 дахь хэсэг:**

“57.17.Энэ хуулийн 57.2.1-57.2.4-т заасан цалингийн нэмэгдлийн дээд хэмжээ нь үндсэн цалингийн 100 хувиас хэтрэхгүй байна. Энэхүү хязгаарлалт нь төрийн албан хаагчийн орон нутагт ажилласны нэмэгдэлд хамаарахгүй.”

### **12/58 дугаар зүйлийн 58.1.3 дахь заалт:**

"58.1.3.энэ хуулиас бусад хуулиар төрийн албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоохгүй байх."

### **13/61<sup>1</sup> дүгээр зүйл:**

**“61<sup>1</sup> дүгээр зүйл. Орон нутаг, алслагдсан бүс дэх төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгаа**

61<sup>1</sup>.1.Нийслэл, аймгийн төвөөс бусад газарт ажилладаг төрийн жинхэнэ албан хаагчид орон нутгийн болон алслагдсан бүсийн нэмэгдэл олгож болно.

61<sup>1</sup>.2.Энэ хуулийн 61<sup>1</sup>.1-т заасан нэмэгдлийг давхардуулан олгохгүй.

61<sup>1</sup>.3.Алслагдсан бүсийн нэмэгдэл олгох бүсийг нийслэлээс алслагдсан байдал, дэд бүтцийн хөгжил зэрэг шалгуурыг харгалзан Засгийн газар тогтооно.”

### **14/78 дугаар зүйл:**

#### **"78 дугаар зүйл. Дагаж мөрдөх журмын зохицуулалт**

78.1.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

78.2.Энэ хуулийн 16.4 дэх хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор үндэсний нийт ажиллах хүчинд эзлэх төрийн албан хаагчдын тоог 2023 онд 16.9 хувиас, 2024 онд 15.7 хувиас, 2025 онд 15 хувиас тус тус хэтрэхгүй байхаар тус тус бууруулна."

**2 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсгийн "27.1.3," гэсний дараа "27.2.3," гэж, мөн зүйлийн 33.10 дахь хэсгийн "байгууллагын" гэсний дараа "болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын" гэж, 57 дугаар зүйлийн 57.7 дахь хэсгийн "57.5.3" гэсний дараа "57.5.4" гэж, 61 дүгээр зүйлийн 61.1.7 дахь заалтын " албан тушаалын цалинг авах;" гэсний дараа "холбогдох шаардлага, шалгуурыг хангасан тохиолдолд төрийн хөрөнгөөр боловсролын зэрэг ахиулах сургалтад хамрагдах;" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэг:**

23.6.Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн ажлын алба, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

## **2/27 дугаар зүйл:**

### **"27 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоог нөхөх, сонгон шалгаруулж томилох**

27.1.Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

27.1.1.тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа энэ хуулийн 23.2-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагчдаас;

27.1.2.шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулж;

27.1.3.энэ хуулийн 16.1-д заасан удирдах албан тушаалтны нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулж;

27.2.Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий этгээд доор дурдсан журмын дагуу уг орон тоог нөхнө:

27.2.1.тухайн төрийн байгууллагад ажиллаж байгаа энэ хуулийн 23.2-т заасан тусгай шаардлагыг хангасан төрийн жинхэнэ албан хаагчдаас;

27.2.2.шатлан дэвших зарчмын дагуу төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас сонгон шалгаруулж;

27.2.3.сул орон тоог энэ хуулийн 27.2.1, 27.2.2-т заасны дагуу нөхөх боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс сонгон шалгаруулж.

27.3.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарч, энэ хуулийн 27.1.1, 27.2.1-д заасны дагуу нөхөн боломжгүй тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 14 хоногт багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, төрийн албаны төв байгууллагад цахим системээр хүргүүлнэ.

27.4.Төрийн албаны төв байгууллага энэ хуулийн 27.3-т заасан захиалгын дагуу сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, шалгарсан нэр дэвшигчийг яам, Засгийн газрын агентлаг, Засгийн газрын түвшний төрийн бусад байгууллагын хувьд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлаас

удирдлага нь томилогддог байгууллагын хувьд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд цахим системээр дамжуулан санал болгоно.

27.5.Төрийн албаны төв байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг томилох зөвшөөрлийг Засгийн газрын Хэрэг газар яам, Засгийн газрын агентлаг, Засгийн газрын түвшний төрийн бусад байгууллагын томилох эрх бүхий этгээдэд цахим системээр хүргүүлэх бөгөөд холбогдох албан тушаалд томилно.

27.6.Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын томилох эрх бүхий этгээд төрийн албаны төв байгууллагаас санал болгосон нэр дэвшигчийг холбогдох албан тушаалд томилно.

27.7.Томилох эрх бүхий этгээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн албаны төв байгууллагын санал болгосон төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд нэр дэвшигчийг томилохоос хуульд заасан үндэслэлээр нэг удаа татгалзах эрхтэй бөгөөд энэ тохиолдолд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон төрийн албаны төв байгууллага өөр хүнийг зохих журмын дагуу санал болгоно."

### **3/29 дүгээр зүйл:**

#### **"29 дүгээр зүйл.Төрийн албан хаагчийн сургалт**

29.1.Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь сургалтад хамруулна:

29.1.1.чиглүүлэх болон мэргэшүүлэх давтан сургалт

29.1.2.албан тушаалын мэргэшүүлэх багц сургалт

29.1.3.богино хугацааны зорилтот сургалт

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтын хөтөлбөр, агуулгыг Монгол Улсын хөгжлийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, төрийн байгууллагын хэрэгцээ, шаардлагад үндэслэн тухайн албан тушаалын онцлог, чиг үүргийг харгалзан Засгийн газар тодорхойлно.

29.3.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтыг Төрийн албаны сургалтын байгууллага төрийн байгууллагын захиалгаар хариуцан зохион байгуулна.

29.4.Төрийн албаны сургалтын байгууллага нь төрийн албан хаагчийг сургах, давтан сургах, төрийн албаны хүний нөөцийн талаар судалгаа, шинжилгээ хийх, энэ талаар бодлого боловсруулагчид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн үүрэгтэй бөгөөд дүрэм, бүтэц, зохион байгуулалт, сургалтыг зохион байгуулах хэлбэр, сургалтыг мэргэшсэн сургалтын байгууллагаар гэрээний үндсэн дээр хийлгэх чиглэлийг Засгийн газар батална.

29.5.Албан тушаалын мэргэшүүлэх багц сургалт нь албан тушаалын ангиллыг харгалзан тэргүүн түшмэлийн, эрхэлсэн түшмэлийн, ахлах түшмэлийн гэсэн төрөлтэй байна.

29.6.Энэ хуулийн 23.2-т заасан тусгай шаардлагыг ханган томилогдсон иргэн холбогдох албан тушаалын мэргэшүүлэх багц сургалтад томилогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хамрагдана.

29.7.Төрийн албан хаагчийн сургалтын зардлыг төрийн байгууллага тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.

29.8.Энэ хуулийн 29.1-д заасан сургалтад тухайн байгууллагын захиалгаар төрийн улс төрийн болон төрийн үйлчилгээний албан тушаалтныг хамруулж болно.

29.9.Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллагаас зохион байгуулах энэ хуулийн 29.1-д заасан сургалтаар төрийн албан хаагч өөрийн зардлаар суралцаж болно."

#### **4/ 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг:**

"33.5.Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалт нь сорил, ярилцлага, тусгай шалгалт нь сорил, ярилцлага болон бусад \тодорхой үүрэг гүйцэтгүүлэх\ хэлбэртэй байна."

#### **5/46 дугаар зүйлийн 46.6 дахь хэсэг:**

"46.6.Энэ хуулийн 46.1-т заасан үндэслэлээр түр чөлөөлөгдсөн, 46.2.1, 46.2.4-т заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэнийг төрийн албан хаагчийн нөөцөд байгаад тооцно."

#### **6/47 дугаар зүйлийн 47.1.1 дэх хэсэг:**

"47.1.1.ажлын гүйцэтгэл, үйл ажиллагааны үр дүнгийн сүүлийн 4 удаагийн үнэлгээгээр 3 удаа "хангалтгүй" үнэлэгдсэн;"

#### **7/64 дүгээр зүйл:**

##### **"64 дүгээр зүйл.Засгийн газрын бүрэн эрх**

64.1.Засгийн газар улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн төрийн албаны хөгжлийн бодлогыг тодорхойлж, төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, төрийн албаны хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх, төрийн байгууллагын гүйцэтгэл, албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлж дүгнэх тогтолцоог бүрдүүлэх, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхтэй.

64.2.Засгийн газрын энэ хуулийн 64.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

64.2.1.төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг тайлагнах;

64.2.2.яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, төрийн албан хаагчийн тоо бүртгэлийг хөтлөх;

64.2.3.төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, сургах, удирдах ажилтны манлайлах ур чадварыг хөгжүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжүүлэх;

64.2.4.яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавих, үүрэг, даалгавар өгөх, хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах, тэдэнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

64.2.5.төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангаж, үр нөлөөг дээшлүүлэх арга хэмжээ авах;

64.2.6.яам, Засгийн газрын агентлаг, орон нутгийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийх, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх;

64.2.7.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа ажилтнуудын тоо бүртгэлийг хөтлөх;

64.2.8.төрийн албаны хүний нөөцийг бүрдүүлж, оновчтой удирдах хүрээнд Засгийн газрын хүний нөөцийн удирдлагын нэгдсэн систем (цаашид “Хүний нөөцийн удирдлагын нэгдсэн систем” гэх)-ийг бүрдүүлж, хөгжүүлэх;

64.2.9.төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх ажлыг арга зүйн удирдлагаар хангах, төрийн албан хаагчийн мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлэх ажлыг зохион байгуулах,

64.2.10.төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах;

64.2.11.хувийн хэвшлийн ажилтны адилтгах албан тушаалын дундаж цалингийн судалгааг гаргах, цалин хөлсний өөрчлөлтийн тухай саналаа төсвийн хүрээний мэдэгдэл хэлэлцэхийн өмнө Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

64.2.12.хуульд заасан бусад бүрэн эрх.

64.3.Энэ хуулийн 29.3-т заасан Төрийн албаны сургалтын байгууллага Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэд ажиллана.

64.4.Хүний нөөцийн удирдлагын системийн хязгаарлалттай болон хаалттай мэдээллээс бусад мэдээлэл олон нийтэд нээлттэй, ил тод байна.

64.5.Хүний нөөцийн удирдлагын системийн үйл ажиллагааны журмыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга батална."

**4 дүгээр зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн "төрийн албаны төв байгууллага" гэснийг "төрийн албаны хүний нөөцийн талаарх Засгийн газар, төрийн албаны төв байгууллагын чиг үүргийг тодорхойлох," гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн "Төрийн албаны төв байгууллага төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийг" гэснийг "Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн мэдээллийн нэгдсэн санг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар" гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн "төрийн албаны төв байгууллагын" гэснийг "Засгийн газрын" гэж, 18 дугаар зүйлийн 18.8 дахь хэсгийн "төрийн албаны төв байгууллагын" гэснийг "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын" гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн "төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн" гэснийг "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу" гэж, 23 дугаар зүйлийн 23.7, 23.8 дахь хэсгийн дугаарыг "23.8, 23.9" гэж, 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх заалтын дугаарыг "31.1.5" гэж, 33 дугаар зүйлийн 33.12 дахь хэсгийн "Засгийн газартай" гэснийг "Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай" гэж, 43 дугаар зүйлийн 43.5 дахь хэсгийн "төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн" гэснийг "хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналын дагуу" гэж, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн "10" гэснийг "5" гэж, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсгийн "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэр гаргана." гэснийг "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн жинхэнэ албан хаагч нь тэтгэвэр тогтоолгох насанд хүрмэгц төрийн албанаас чөлөөлөгдөх, эсхүл төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацааны хүрээнд тодорхой хугацаанд ажиллах хүсэлтээ гаргана. Уг хүсэлтийг тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч төрийн албанаас чөлөөлөх, эсхүл түүний үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингийн үнэлгээ, туршлага, эрүүл мэндийн байдал зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр төрийн алба хаах насны дээд хязгаар хүртэлх хугацааны хүрээнд тодорхой хугацаанд үргэлжлүүлэн ажиллуулах шийдвэрийг 1 удаа гаргана." гэж, 47 дугаар зүйлийн 47.1.4 дэх заалтын дугаарыг "47.1.5" гэж, 52 дугаар зүйлийн 52.1 дэх хэсгийн ", мэргэшлийн түвшинг" гэснийг " болон мэргэшлийн түвшин, ур чадварыг" гэж, 52.2 дахь хэсгийн "үр дүнг" гэснийг "үр дүн болон мэргэшлийн түвшин, ур чадварын үнэлгээг" гэж, 57 дугаар зүйлийн 57.15, 57.16 дахь хэсгийн "итгэлцүүр, шатлалыг" гэснийг "хэмжээ, сүлжээг" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.3 дахь хэсгийн "сургалт судалгаа" гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.** Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, 24 дүгээр зүйл, 57 дугаар зүйлийн 57.9, 57.10, 57.13, 57.17 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1.2, 66.1.9 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг